

МОНГОЛ УЛСЫН ГАДААД  
БОДЛОГО, ХАМТЫН  
АЖИЛЛАГАА

МОНГОЛЫН ГАДААД БОДЛОГЫН  
ШИНЭЧЛЭЛИЙН ТУХАЙ ХУВИЙН  
БОДОЛ

*Х.Олзвой\**

Хүйтэн дайн дууссаны дараа Монгол улсын дотоод, гадаад байдал үндсээрээ өөрчлөгдсөн билээ. Тухайлбал:

-Монгол улс ардчилал, чөлөөт зах зээлийн замд гарав. Энэ нь тус улсын ойрын үеийн түүхэнд анх удаа гадаад бодлогоо үндэснийхээ эрх ашигт нийцүүлэн өөрчлөх дотоод улс төр, эдийн засгийн нөхцөл, шаардлагыг бүрдүүлэв.

-ЗХУ задарч хэд хэдэн улс болон бутарсаны дараа яг манайтай хил залган үлдсэн ОХУ төр улсаа тохинуулж шинэ замд гарах бэрхшээлт үедээ оров.

-Манай өөр нэг хөрш БНХАУ дотоодынхоо улс төр, эдийн засгийн бүтцийг онц өөрчлөлгүй шинэ байдалд бодлого санаагаа зохицуулж чадав. Орос улсын Ази Номхон далай дахь байр суурь нимгэрч харихын хамт түүний хэт их гүрэн байсан үе нь аргагүй доройтон буурсан учраас БНХАУ бүсийн хэт их гүрэн болох боломж нь үнэхээр өсөв.

-Монгол улс Өрнөдийн болон бусад ардчилсан улсуудаас сэтгэл санаа, улс төр, эдийн засгийн дэмжлэг авч техник тусламж эрэлхийлэх бололцоог анх удаа олж авав.

-Монгол орон хөрш хоёр гүрнийхээ хувьд стратегийн хувьд чухлаар байрласан завсрын талбай байх ач холбогдол нөгөөдүүлийн хувьд өөрчлөгдөн нэмэгдэв.

Товчхон хэлбэл, 1990 оноос өмнө Монгол улсын гадаад бодлого хоёр их хөршийнхөө Төв Ази дахь стратегийн бодлогын барьцаанд байсан үе дуусч өөрийн бодлогыг цаашдын ирээдүйд нийцүүлэн бүс нутаг, дэлхий дахины өнгө аясыг нь харгалзаж үндэсний эрх ашгаа дээдлэн өөрчлөх бодит бололцоо бүрэлдэв.

-Ийнхүү гадаад бодлогоо шинэчлэх үйл явц Монголын нийгмийг ардчилах үетэй зэрэгцэн явааг бас тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь бодит бололцоо, нөхцлийг тусгасан, бие даасан гадаад бодлогыг зөвхөн ардчилсан засгийн газар хэрэгжүүлдэг бөгөөд социалист үзэл суртал, коммунист найзлал бол жижиг үндэстэн буюу улс эрх ашгаа хамгаалах боломж олгодоггүйгээр зогсохгүй зөвхөн социалист лагерийн эв нэгдлийг л бэхжүүлэх нь зохих байдалд хүргэдгийг харуулж байгаа юм.

Монгол улсын гадаад бодлогыг шинэчлэн тодорхойлох үйл явц 1990-ээд оны бүр эхнээс үндэс сууриа тавьсан билээ. 1990 оны гуравдугаар сард Монголын засгийн газар БНСУ-тай дипломат харилцаа тогтоох шийдвэрийг хойд их хөрштэйгөө зөвлөлгүй гаргаж мөн оны наймдугаар сард ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн АНУ-ын тэр үеийн төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкертэй хэвлэлийн бага хурал Улаанбаатарт хийж Кувейтийн эсрэг хийсэн Иракийн түрэмгийлэлийг эсэргүүцэж буйгаа зарлахын хамт АНУ-ын байр суурийг шууд дэмжсэн зэрэг нь гадаад бодлогын шинэчлэлийн эхлэлтийн бодит алхам байсныг харуулсан болов уу. Мөн тэр үеийн АИХ-ын тэргүүлэгчдийн дарга, одоогийн ерөнхийлөгч П.Очирбат

\*Х.Олзвой, дэд доктор ГХЯ-ны бодлого зохицуулалтын газрын дарга.

БНХАУ-д айлчилж хоёр орны харилцаа хэвийн болсныг зарласан явдал ч түүний нэг илрэл мөн.

Ийнхүү алхам алхмаар ахисаар 1994 оны 6 дугаар сард Монгол улсын гадаад бодлогын болон аюулгүй байдлын үзэл баримтлал гэх мэт чухал баримт бичгийг УИХ батлан цоо шинэ нөхцөлд оруулсан билээ. Гадаад бодлогын үзэл баримтлалд дурдсанаар, Монголын гадаад бодлого **нэгдүгээрт**, тус орны аюулгүй байдлыг болон үндэсний эрх ашгийг улс төр, дипломатын аргаар хамгаалах, **хоёрдугаарт**, улс орны эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, техникийн дэвшлийг хангах гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх нь гадаад бодлогын дээд зорилт болой. Нөгөөтэйгүүр энэ баримт бичиг түүхэн бөгөөд бодит байдалд үндэслэн гадаад бодлогын зорилго, чиглэл, зарчим зэргийг тодорхойлсон нь нэн чухал ач холбогдолтой юм. Гэхдээ гадаад бодлогын шийдвэр гаргах, дипломат үйл ажиллагаа явуулах явцад олон улсын харилцааны янз бүрийн байдалтай тулгарч болохыг уг баримт бичигт анхаарсан билээ. Түүнээс гадна бусад улс, үндэстний байдал, ашиг сонирхол, нөхцөл бололцоог гадаад бодлогын тодорхой алхам хийх, яриа хэлэлцээ явуулахдаа анхаарах ёстойг хэлэх хэрэгтэй. Гадаад бодлогын үзэл баримтлалын 4 дүгээр зүйлд гадаад бодлогын алхмыг боловсруулахдаа олон улсын харилцааны хөгжилт, бүс нутаг, дэлхийн байдал нөхцлийг анхаарч уян хатан байхын чухлыг заасан юм.

Анхаарал татмаар бас нэг асуудал гэвэл том, жижиг орнуудын гадаад бодлогын зорилт ялгаатай байдаг явдал юм: Том, жижиг ч бай улс орнууд олон улсын харилцаанд оролцоходоо эрх тэгш гэж ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн зарчим байдаг ч том орнуудын бодол санааг дагах хандлага байсаар байна. Ингэж буй нь том гүрнийг даган тэдний үзэл суртал, зорилгод автах бус, харин тэд олон улсын харилцааг өөрчлөн байгуулахад илүү үүрэгтэй хийгээд жижиг, бага улсуудын үндэсний эрх ашгийг хамгаалах талаар дэлхий дахины дэмжлэгийг дайчлах талаар илүү хариуцлагатай гэдгийг харуулж байна гэж бодогддог. Бага буурай улсууд, тэр тусмаа том гүрнүүдийн дунд оршдог орнууд өөрийн аюулгүй байдлаа хангах, тусгаар тогтнолоо бататгахын тулд “тэнцвэржүүлэгч” гүрэнг эрэлхийлэх, тэдний дэмжлэг туслалцааг хайх нь зүйн хэрэг юм. Манай орон ч гэсэн бүх улс гүрэн, ялангуяа Өрнө, Дорны хөгжингүй орнуудтай өргөн харилцах, тэдний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрэлдүүлэхийг зорьж буй нь учиртай. Үүнийг манай гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагааны хоёр дахь чиглэл нь Өрнө, дорны өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцааг хөгжүүлэх явдал мөн” хэмээн илэрхийлсэн байдаг.

Тэгэхдээ Монгол улс ОХУ, БНХАУ гэсэн хоёр их хөрштэйгөө хөгжүүлж буй харилцаандаа **тэргүүлэх ач холбогдол** өгдөг нь аргагүй юм. Гадаад бодлогын үзэл баримтлалдаа бид анх удаа хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харилцаа барихаа ил тодоор зарласан нь зөвхөн ЗХУ-ыг түшиглэсэн хуучин бодлогыг шинэчлэсний илрэл болой. Энэ талаар олон бодит алхам хийж урд хөрштэйгөө худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлж дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээг тогтмолжуулж хоёр хөрштэйгөө харилцан хамтын ажиллагаагаа шинэ цаг үетэй нийцүүлэн өөрчилж шинэ хэлбэр, агуулгатай болгож байгааг олон баримтаар нотлож болох юм.

Гадаад бодлогын үзэл баримтлалын нэг онцлог нь Монгол улс эвсэлд үл нэгдэх бодлого баримтлах болсноо зарласан явдал юм. Эвсэлд үл нэгдэх бодлого гэдэг нь улс гүрнүүдийн бодлого, сөргөлдөөнд аль нэг талыг барихгүй гэсэн үг гэж тайлбарламаар. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн болохдоо манай улс дорхи чиг шугамыг удирдлага болгосон гэж хувьдаа бодож байдаг. Тухайлбал:

-Эдийн засгийн хувьд Монгол бол хөгжиж буй орон бөгөөд хөгжиж буй бусад оронтой олон зорилго, чиглэлээр адил бөгөөд эдгээрийг шийдвэрлэхэд тэдэнтэй хамтран ажиллах өргөн бололцоог олж авсан:

-Улс төрийн талаар гэвэл, бүс нутаг, дэлхий дахины асуудлыг хэлэлцэхэд нөлөө, нэр хүнд нь өсч буй эвсэлд нэгдээгүй орнуудын багт орсноор манай олон улсын байр суурь ихээхэн бэхжсэн;

-Стратегийн хувьд, хоёр хөрш гүрэнтэйгээ харилцаагаа бүхэлд нь тэнцвэртэй болгох бололцоог эвсэлд үл нэгдэх чиглэл өгсөн юм.

Тэгэхдээ манай улс төвийг сахисан улс гэж зарлаагүй нь нийгмийн чиг баримжаа барих цэрэг, эдийн засгийн хүч чадал нь нэн дутууд оршиж буй гэж үздэг.

Үзэл баримтлалд заасанчлан Монгол Улс нь **“нээлттэй бодлого баримтлана”**. Үүний утга нь манай улс гадаадын бүх оронтой харилцан ашигтай эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа хөгжүүлж хөгжингүй орнуудын бодит сонирхолыг эх орондоо бий болгоно гэсэн үг гэж ойлгож байна. Ингэхдээ энэ нь аль нэг орноос хэт хараат байдалд орох хийгээд Монголын аюулгүй байдал, улс төрийн тусгаар тогтнолд занал учруулахад хүргэх ёсгүй. Энэ тухай үзэл баримтлалын 16 дугаар зүйлд тодорхой заасан байдаг юм.

Нээлттэй бодлого явуулах бас нэг шаардлага нь төвлөрсөн эдийн засгаас зах зээлд шилжих үндсэн чиг шугамтай холбоотой. Өнөөгийн нөхцөлд дэлхийн бүх орнуудтай харилцахгүйгээр, хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлж, эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулалгүйгээр, бүс нутгийн интеграцид орж байр сууриа бэхжүүлэхгүйгээр зохистой эдийн засгийн хөгжлийг хангаж эдийн засгийн өнөөгийн бэрхшээлийг даван туулж чадахгүй нь бусад орны туршлагаас ч харагдаж байна.

Өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэхэд онцгой анхаарч нээлттэй бодлогын ид шидийг сайн үзмээр байна. 1993 онд шинэчлэн баталсан гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, газартай холбогдсон хуулиуд, гааль, татварын хуулийн заалтууд энэ чиглэлд чухал алхам болсон гэж үздэг. Гэвч эдгээр хуулиудын зарим заалт хатуу, зарим нь зөрчилтэй, газрын өмчлөл, түрээсийн тухай ойлголт, байр суурь эцэслэн цэгцрээгүй байгаа тухай яриаг таслан нэг мөр болгууштай. Ингэвэл асуудал ядаж хууль зүйн талаасаа жигдрэх юм. Нөгөө нэг зүйл бол мэдээлэл, сурталчилгаа бөгөөд гадаадын туршлагаас харвал нэг салбарт тодорхой зардал гаргаж үр дүнд хүрдэг ажээ. Гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлд бас аж ахуйн хүнд суртлыг арилгах, хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэх, салбарын биш үндэсний хөгжлийн эрх ашигт нийцсэн зохицуулсан бодлого явуулах зэрэг олон асуудал ордог бололтой. Худалдаа үйлдвэрийн яамны тоо баримтаас үзэхэд Монголд 1990 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалттай 552 аж ахуйн газар байгуулагдаж гадаадаас орж ирсэн хөрөнгө оруулалт 115 сая ам.долларт хүрчээ. Тооны талаас нь үзвэл,

юуны өмнө ОХУ-тай 182, БНХАУ-тай 172, АНУ-тай 21, Японтой 34, Казахстантай 4, Гонконгтой 18, БНСУ-тай 16, Сингапуртай 10-н хамтарсан аж ахуйн нэгж байгуулсан байна. Гадаадаас оруулсан хөрөнгийн байдлаас харвал, АНУ-аас 44,8 сая ам.доллар, Японоос 15 сая, ОХУ-аас 13,5 сая, БНХАУ-аас 12 сая гаруй ам доллар орсон дүн харагдаж байна. Таван удаа Монголыг дэмжигч, хандивлагчдын зөвлөлгөөн хийгээд байна.

Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалд гео-эдийн засгийн асуудал нилээд сайн тусгалаа олсон бөгөөд үүнийг хөгжил, аюулгүй байдлын үзэл санааны үүднээс маш зөв ойлгож бодит арга хэмжээ авах явдал чухал байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасан “**Олон тулгуурт бодлого**”-ын үзэл санааг дэлгэрүүлж тайлбарлахыг оролдъё. Миний бодлоор энэ нь нэгдүгээрт, манай гадаад бодлогын зургаан тэргүүлэх чиглэлийг зааж үндэсний эрх ашгаа дээдлэн бүх улс, олон улсын байгууллагуудтай үзэл суртал, нийгэм, эдийн засгийн байгууламж зэргийг үл харгалзан хамтын ажиллагаа хөгжүүлэхийг тодорхойлж байна, хоёрдугаарт манай гадаад бодлогын үзэл баримтлалд улс төр, эдийн засгийн гадаад бодлогын чиглэлээр зогсохгүй шинжлэх ухаан, технологийн болон соёл, хүмүүнлигийн салбар дахь бодлогын агуулгыг тодруулан багтаасан юм, гуравдугаарт, Монгол Улс бол дэлхийн хамтын нийгэмлэгийн хариуцлагатай нэг гишүүн бөгөөд дийлэнх олонхийн үнэт зүйлсийг хуваалцдаг бөгөөд хүний нийгмийн урагшлан давших хандлагыг дагасан орон гэдгийг үзэл баримтлалд онцлон дурджээ. Энэ нь Монгол орон олон түнш, олон “найз”-тайг давхар харуулах баримт буюу.

Ийнхүү “олон тулгуурт” бодлогын цөм нь Монголын гадаад бодлогын олон талт, прагматик шинж төрхийг харуулж байгаа бөгөөд ийм учраас манай аюулгүй байдлыг хангах, үндэсний эрх ашгийг хамгаалахад нэн чухал агуулгатай үзэл санаа юм.

Монголын гадаад бодлогын 1990-ээд оны онцлог бол **Ази руу ихээхэн чиглэсэн** явдал билээ. Энэ нь юугаар илэрч байна вэ гэвэл:

-Монгол Улс бол Азийн соёл иргэншлийн хэсэг мөнийгөө анх удаа албан ёсоор зарлаж Ази Номхон далайн сав газрын орнуудтай янз бүрийн салбарт хамтын ажиллагаа, хэлхээ холбоогоо өргөжүүлэхээ тунхагласан юм.

-Үзэл баримтлалд дурдсанчлан, “Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно

-Азийн орнуудтай хоёр талын харилцаагаа өргөтгөхийн хамт Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) байгууллага зэрэг бүсийн байгууллагуудын үйл ажиллагаанд бололцоо, нөхцөл бүрдэхийн хэрээр оролцох чиглэл барьж байна. Саяхан Монгол Улс АПЕК-ийн тээвэр, холбоо, худалдаа, жуулчлалын асуудал хэлэлцдэг ажлын хэсгүүдэд оролцох хүсэлтээ албан ёсоор илэрхийлсэн билээ. Уг байгууллагад гишүүнээр элсэх өргөдлөө өгсөн боловч эдийн засгийн хөгжлийн өнөөгийн төвшин, бүсийн орнуудын худалдаа эдийн засгийн хэлхээ холбоо тогтоосон байдал зэрэг хүчин зүйлийг бодолцож удаан хугацааны бэлтгэл хийх шаардлагатай нь ойлгомжтой.

Харин манай улс Азийн хөгжлийн банк, АНДЭЗНК-тэй хамтын ажиллагаа өргөтгөсөөр байна.

-1990 оноос хойших хугацаанд Азийн орнуудтай дээд, өндөр төвшинд харилцан айлчилж яриа хэлэлцээ хийх, харилцааны үндсийг тодорхойлсон томоохон гэрээ, хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах явдал байнгын шинж чанартай болж байна. БНХАУ-ын дарга, ерөнхий сайд нар Монголд хэдэн арван жилийн дараа анхны айлчлал хийж манай дээд удирдагчид өмнөд хөршид 5 удаа албан ёсоор айлчлав. Монголын ерөнхийлөгч БНСУ, Энэтхэг, Тайланд, Вьетнам, Лаост, ерөнхий сайд Казахстан, Япон, Сингапур, Малайзид, УИХ-ын дарга Япон, Энэтхэг, Тайландад айлчлав. Мөн Австралийн амбан захирагч, Япон, Балбын ерөнхий сайд нар, Казахстан, Киргизийн ерөнхийлөгчид манай оронд албан ёсны айлчлал хийлээ.

Эдгээр айлчлалын явцад найрамдал, хэмтын ажиллагааны гэрээ, хөрөнгө оруулалтыг харилцан дэмжиж хамгаалах тухай хэлэлцээр, эдийн засгийн харилцааны тухай хэлэлцээр гэх мэт олон арван чухал баримт бичгүүдэд гарын үсэг зурж харилцааны эрх зүйн үндэс шинэ нөхцөлд нийцэн бий болж бэхжиж ирлээ.

-Гадаад бодлогын үзэл баримтлалд Азийн бодлогыг тусгахдаа Зүүн хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү ач холбогдол өгсөн нь манай орны газар зүйн байршил, түүхэн холбоо хэлхээ, хэтийн харилцааг бодолцсон шинэлэг хандлага мөн. Энэ салбар бүсэд бүрэлдэж буй хамтын ажиллагааны уур амьсгалд “дасах”, Зүүн Хойд Азийн эдийн засгийн чуулга зэрэг засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох, Түмэн голын сав газар, Зүүн Хойд Азийн эдийн засгийн хөгжлийн зөвлөлцөх комисс зэрэг засгийн газар хоорондын байгууллагад үүсгэгч гишүүн болон нэгдэх зэрэг бодит алхам хийж эхэлсэн нь дээр бодлогын бодит илрэл юм.

*Зүүн Хойд Ази, Төв Азийн тухай сэдэвтэй холбогдуулан хувийн зарим санаагаа сийрүүлбэл:*

Монгол орныг түүхийн болон газарзүйн хувьд Төв Азид багтааж үзэж ирсэн билээ. Монгол орны цаашдын хөгжил, улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхлоос ургуулан бодвол өнөөдөр дээрх ойлголтод шинэчлэл хийх цаг болсон мэт санагддаг юм. Төв Ази руу чиглэн хөгжих нь манай орны хувьд олон талаар ашиггүйг зөвхөн дорхи хэдэн баримт нотлож байна.

*Үүнд:*

-Төв Азийн гэх олонхи улс нь саяхан тусгаар тогтносон бөгөөд төр улсын хувьд төгөлдөржиж гүйцээгүй, олон улсын хамтын ажиллагааны туршлага багатай,

-бүс нутгийн нийт улс төр стратегийн байдал өнөө хэр нь тогтворжоогүй бөгөөд урьдчилан таамаглах магадлал багатай;

-Төв Азийн олонхи улсын эдийн засаг Оростой гүнзгий интеграцчилагдаж хойшоо чиглэснээс гадна техник, технологийн хөгжлийн хувьд давуу байдалд хүрэх яагаа ч үгүй;

-Дэд бүтцийн хувьд төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд санхүүгийн болон бусад хүндрэл нь ойрын олон жилд хөрөнгө оруулалтыг ихэсгэх бололцоог хаасаар байх төлөвтэй.

Түүнээс гадна энэ бүс нутагт улс төр, шашны олон асуудал байдгийг ч анхаарах ёстой.

Энэ бүхнийг үндэслээд манай улсын хөгжлийн зорилт, стратегийн үүднээс газарзүйн сэтгэл зүйгээ өөрчлөж “**Зүүн Хойд руу зүглэн хөгжих**” бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг санал болгож байна. Энэ нь XXI зуун Ази, Номхон далайн зуун болох магадлалтай холбоотойгоос гадна манай орны хувьд хөгжлийн ийм бодлого баримтлах нь стратегийн шаардлага болж байна гэж үзнэ. “Зүүн Хойд руу зүглэн хөгжих бодлогын наад захын нааштай талууд гэвэл:

-Монгол улс хоёр хөршөөсээ гадна стратегийн хувьд АНУ, БНСУ, Япон зэрэг технологийн хувьд хөгжингүй орнуудын эдийн засгийн “шүхэр” дор орно;

-Оросын Алс Дорнод, Хятадын Зүүн хойд мужууд, түүнчилэн БНАСАУ-тай эдийн засаг, худалдааны өргөн харилцаатай болох боломжийг нээнэ;

-Зүүн хойд Азийн орнуудтай төмөр зам, хуурай болон агаарын замаар холбогдож Түмэн голын төслийг хэрэгжүүлэхийн хэрээр далайд гарах шинэ боломжтой болно;

-Монголын Дорнод хэсэг байгалийн баялаг болоод хөдөө аж ахуйн хөгжлийн боломж ихтэй бөгөөд энд гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж түргэн хөгжих бололцоо гарна,

-Дэд бүтэц, жуулчлал хөгжиж улмаар Монгол улс ЗХУ, Европыг холбосон “газар гүүр” болох зам нээгдэнэ.

Ийнхүү санал болгож буй бодлогын гол сүнс нь одоогийн байгаа сайхан боломжийг бүрэн дүүрэн ашиглаж улмаар улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын шинэ нөхцөл, бололцоотой болоход оршино.

Зүүн хойд Азид эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх сайхан боломж бүрэлдсээр байгааг Түмэн голын сав газрыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээн дэх үйл ажиллагаа харуулж байгаа билээ. Гэвч улс төр, цэрэг, сэтгэл зүйн хувьд “хүйтэн дайн”-ы үлдэгдэл цухалзсаар байгаа ч харилцан ойлгох, итгэлцэх уур амьсгал аажмаар бүрэлдсээр байгааг хэлэх хэрэгтэй.

\* \* \*

Ийнхүү Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал шинэ нөхцөлд бүрэлдэн бий болж хуульчлагдан батлагдсан юм. Үзэл баримтлалын зарим хэсгийг тайлбарлаж санаа бодлоо хэлэхийг хичээхдээ ЗХА руу чиглэсэн бодлого явуулах тухай саналаа товч гаргалаа. Монгол улсын гадаад бодлого бие даасан, прагматик, үндэсний эрх ашигт нийцсэн шинж төрхтэй болж улс, нийгмийн хөгжлийн зорилттой салшгүй холбоотой болсонд шинэчлэлийн гол агуулга оршиж байна. Үүний сацуу Монголын дипломат албанд ч шинэ хандлага бий болж байгааг дурдах нь зүйтэй.

Юуны өмнө гадаад бодлогын шийдвэр гаргах механизм өөрчлөгдлөө. 1990 онд Монгол Улс ардчилалын замд шилжихээс өмнө нь МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчоо бүх салбарын асуудлаар, түүний дотор гадаад бодлогын үйл ажиллагааны талаар шийдвэр гаргаж байв. 1992 онд батлагдсан Монгол Улсын үндсэн хуулийн дагуу УИХ, Ерөнхийлөгч, засгийн газар гадаад бодлогын чиглэл, зарчим, бодит алхмыг тодорхойлж байх болсон юм.

ГЯЯ-ыг Гадаад харилцааны яам болгон үүрэг, зорилтыг нь тодотгон өргөтгөсөн билээ. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гадаад

бодлогын төлөвлөлт, зохицуулалт, тодорхой асуудлаар баримтлах байр суурийг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэх боллоо.

Өөр нэг шинэ гэмээр хандлага бол монголын дипломат албанд буюу гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд улсын ерөнхийлөгч, УИХ-ын дарга, ерөнхий сайд нарын үүрэг илүү нэмэгдэж тэд олон оронд айлчилж дээд хэмжээний уулзалт хийж хоёр болон олон талт харилцааны тодорхой асуудлыг шийдвэрлэдэг болж байна.

Гадаад харилцааны үйл ажиллагаанд олон нийт, нам, эвслийн зүгээс хяналт тавих явдал мэдэгдэхүйц сайжирч хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр гадаад бодлогын үйл ажиллагааг мэдээлэх, тоймлох, санал дүгнэлтээ сурталчлах нь нэмэгдлээ.

ГХЯ, ДТГ-уудын үйл ажиллагаа судалгаа, мэдээлэл, иргэдийн эрх ашгийг хамгаалах, эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх зэрэг салбарт идэвхжиж тодорхой үр дүнтэй ажиллах болсон нь анзаарагдаж байна. Дипломатч нарын бие даан сэтгэх, өөрийн ур, ухааныг уралдуулах, хэлэлцээ ярилцлага хийх чадвар ч өсч байгааг бодит туршлага харуулж эхлэв.

Энэ бүхнээс үзвэл, Монгол Улсын гадаад бодлогын зарчим, чиглэл цоо шинээр тодорхойлогдож, дипломат албанд ч шинэлэг хандлага лавширсаар байна.

МОНГОЛ ДАХЬ ХИЛИЙН БҮСҮҮДИЙН ЭДИЙН  
ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ  
ХЭТИЙН ТӨЛӨВ

*Сакура Кожима\**

1. Хилийн худалдаа хөгжүүлэх нь далайгаас алслагдсан орны хилийн бүсүүдийн хөгжлийн шинэ стратеги мөн.

Монгол шиг далайгаас алслагдсан орны эдийн засагт гадаад эдийн засгийн харилцааны ач холбогдолыг хэтэрхий өргөх гээгүй билээ. Хил нийлж байгаа орнуудын хооронд бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь далайгаас алслагдсан орон буюу бүсэд их ач холбогдолтой нь магадтай. Азийн ШАҮО буюу АСЕАН-ы орнуудын эдийн засгийн амжилттай хөгжлийн загвар нь далайн чанад дахь зах зээлд хялбар хүрэх эрэг орчмын газарзүйн таатай байршлын нийтлэг шинж юм. Экспортын амжилт нь хөгжиж байгаа үндэстний эдийн засгийн нийт хөгжлийн гол эх үүсвэр мөн бөгөөд газарзүйн байршил шийдвэрлэх урьдчилсан нөхцөл нь болно. Монгол эрдсийн баялаг нөөцтэй боловч өөрийн байршил, хоцрогдонгуй дэд бүтэц зэргээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байна. Дэд бүтцийн доголдлоос гадна ажиллах хүчин дутагдалтай эдийн засаг нь гадаадын фирмүүдийг урихад үнэхээр ашиггүй байна. Ажиллах хүчээр хомс эдийн засагт ажиллах хүчин амархан шавхагддаг учраас өртгийн зардал аяндаа өсөн гадаадын пүүсүүдийн ашиг аяндаа алдагддаг. Яагаад гэвэл ажиллах хүчний нөөцийн ачаар цалинг доогуур барьж байж болдог байна. Монголд далайгаас алслагдсан байршил (бас хоцронгуй дэд бүтэц)

\*Токай Их Сургуулийн эрдэмтэн

1 ШАҮО-шинээр аж үйлдвэржсэн орнууд